



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорнод аймаг дахь Цагдаагийн газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДОА-2020/73/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Чойбалсан хот 2020 он	Дорнод аймаг дахь Төрийн газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор: Б.Болортуул Утас: 70584203 Цахим хаяг: Bolortuulb@audit.gov.mn Аудитын менежер: В.Цэнгэлмаа Утас: 70584204 Цахим хаяг: Tsengelmaav@audit.gov.mn Ахлах аудитор: Д.Нармандах Утас: 70584207 Цахим хаяг: Narmandakhd@audit.gov.mn
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ДОА	Дорнод аймаг дахь Төрийн аудитын газар
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч



Аудитын гэрчилгээ	3
Аудитын тайлан	5
2.1. Оршил.....	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	7
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	8
2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	9
2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	9
2.13. Шилэн дансны мэдээлэл.....	9
2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	9
2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	10
Менежментийн захидал	11
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан	12
1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	12
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	13
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	14
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	15
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	16



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000, Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2020.02.13 № 52

танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорнод аймаг дахь Цагдаагийн газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Дорнод аймаг дахь Цагдаагийн газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн Сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын Олон Улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Дорнод аймаг дахь Цагдаагийн газрын 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

110519532



Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн Сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ



2.1. Оршил

Дорнод аймаг дахь Цагдаагийн газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг дарга, цагдаагийн хурандаа Т.Ганзориг танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй, болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорнод аймаг дахь Цагдаагийн газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорнод аймаг дахь Цагдаагийн газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 дугаар сарын 05-наас 2020 оны 02 дугаар сарын 07-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 124-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, ахлах аудитор Д.Нармандах хариуцаж хэрэгжүүлэв.

Дорнод аймаг дахь Цагдаагийн газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 36/172 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Төрийн аудитын байгууллагаас



санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Дорнод аймаг дахь Цагдаагийн газрын үйл ажиллагааны эрхэм зорилго нь “хуулийг дээдлэн, хүний эрхийг хамгаалж, амар тайван амьдралын баталгааг хангах”-д оршино.

Цагдаагийн газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Гэмт хэрэгтэй тэмцэх
- Нийгмийн хэв журам хамгаалах
- Олон нийтийн аюулгүй байдлыг хангах

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Дорнод аймаг дахь Цагдаагийн газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Дорнод аймаг дахь Цагдаагийн газрын нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Acolous” программ хангамж ашигладаг байна.

Дорнод аймаг дахь Цагдаагийн газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Дорнод аймаг дахь Цагдаагийн газрын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 21 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны



жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг дунд гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 2,816,829.2 мянган төгрөгөөс тооцон 56,336.6 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 61,864.5 мянган төгрөгөөр тооцсон болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Дорнод аймаг дахь Цагдаагийн газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 119,411.5 мянган төгрөгөөр буюу 4,1 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан урьдчилж гарсан зардал, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	-	-
Урьдчилгаа	6,774.1	13,222.7	6,448.6
Бараа материал	241,408.4	246,875.1	5,466.7
Үндсэн хөрөнгө	2,618,725.9	2,726,222.1	107,496.2
Нийт хөрөнгө	2,866,908.4	2,986,319.9	119,411.5
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	2,866,908.4	2,986,319.9	119,411.5
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	2,866,908.4	2,986,319.9	119,411.5

Авлага дансны үлдэгдэл өссөн /буурсан асуудал байхгүй.

Урьдчилгаа дансанд НИК ХХК-д шатахууны үнэ 12,061.1 мянган төгрөг, Найнги ХХК-д нүүрсний үнэ 1,161.0 мянган төгрөг, нийт 13,222.7 мянган төгрөгийг шилжүүлэн байршуулсан нь цагдаагийн газрын зайлшгүй нөөц буюу олон нийтийн аюулгүй байдал, гэмт хэрэг, нийгмийн хэв журам хамгаалахад урьдчилан сэргийлэх төлөвлөгөөтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл өссөн нь хамгаалалтын хашаа, цагдаагийн байгууллагын алба хаагч нарт ашиглах, улсын бүртгэлийн мэдээллийн сантай шууд холбогдох эрх бүхий “Data сим” карт шинээр авснаас шалтгаалсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэлд цагдаагийн алба хаагч нарын хэрэгцээнд өдөр тутам ашиглагдаж байгаа болон бэлэн байдлын үед ашиглах тусгай зориулалтын 69.9 сая төгрөг, аж ахуйн 121.0 сая төгрөгийн хангамжийн материал, 443 толгой 55,860.0 мянган төгрөгийн мал амьтад байна



Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн нь улс болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэнтэй холбоотой байна.

Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 78,309.6 сая төгрөгийн барилга байгууламж, авто тээврийн хэрэгсэл, төсвийн хөрөнгөөр худалдан авсан 7,840.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, шилжүүлэн авсан 94,822.5 мянган төгрөгийн батлан хамгаалах тоног төхөөрөмж, дахин үнэлгээгээр нэмэгдсэн 90,235.0 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгө данс аймгийн ИТХ-ын тогтоолоор акталсан 84.435,7 мянган төгрөгийн хөрөнгөөр хасагдсан байна.

Биет бус хөрөнгө буурсан нь цахим орчин /онлайн/-д шилжсэнтэй холбоотой 2002 оны архивын программыг акталснаас шалтгаалжээ.

Өр төлбөр байхгүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,986,319.9 мянган төгрөг болж 119,411.5 мянган төгрөгөөр өссөн нь малын нас дэвшилтийн орлого нэмэгдсэн, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт хийгдсэн, үндсэн хөрөнгийг дахин үнэлсэн зэргээс шалтгаалжээ.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд зааснаар Цагдаагийн газрын тайлант онд 57,326.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 57,269.4 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 99.9 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 2. Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Туслах үйл ажиллагааны орлого	57,326.0	57,269.4	56.6	99.90
Нийт дүн	57,326.0	57,269.4	56.6	99.90

Туслах үйл ажиллагааны орлого 56.6 мянган төгрөгөөр тасарсан байна.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрт зориулан үндсэн үйл ажиллагаанд 2,753,713.0 мянган төгрөгийн төсөв батлагдсан нь урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 2,696,387.0 мянган төгрөгийг улсын төсвөөс, 57,326.0 мянган төгрөгийг үндсэн болох туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,753,626.4 мянган төгрөг буюу 99.9 хувьтай байна.



Нэмэлт төсөв: Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчаас гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны зардалд 120,425.7 мянган төгрөг, Байгаль орчин аялал жуулчлалын газраас түймрийн зардалд 2,340.0 мянган төгрөг, нийт 122,765.7 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилтийг шилжүүлсэн байна.

Үүнээс гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардалд 100509.8 мянга төгрөг, ой хээрийн түймрийн зардалд 22,255.9 мянган төгрөгийг зарцуулсан байна.

2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 21 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 21 эрсдэл тодорхойлж нийт 21 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 14,086.7 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 864.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 13,222.7 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

Аудитаар дараах 864.0 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчилд төлбөрийн акт тогтоолоо. Үүнд:

1. Сувилалд амарсан 9 ажилтанд томилолтын зардал гэж 864.0 мянган төгрөгийг олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалт, санхүүгийн тайлангийн үнэлгээ, хэмжилт, үнэн зөв батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

Аудитаар илэрсэн 13,222.7 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Цалинд дахин тооцоолол хийхэд даргын тушаалаар сахилгын шийтгэл ногдуулсан 36,533.4 мянган төгрөгийг цалингийн нэмэгдэл талд хасах дүнгээр бичиж цалинг бууруулах бичилт хийсэн байна. Цагдаагийн байгууллагын системийн хэмжээнд уг бичилт хийгдэж байгаа гэсэн тайлбар өгсөн тул нэгтгэсэн тайланд хийх аудитаар шийдвэрлүүлэх саналтай байна.

2.13. Шилэн дансны мэдээлэл

Дорнод аймаг дахь Цагдаагийн газар нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 142 мэдээллийг хугацаанд нь, 2 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмж өгөгдөөгүй байна.



2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Дорнод аймаг дахь Цагдаагийн газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Дорнод аймаг дахь Цагдаагийн газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.



Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Урьдчилгаа данстай холбоотой асуудал

- 1.1. Илрүүлэлт: Түлш, шатахууны төсвийн 13,222.7 мянган төгрөгийг урьдчилгаа зардлын дансанд бүртгэн нөөц бэлтгэсэн байна. Нөөцийн хэмжээг тогтоосон зохицуулалт байхгүй, жил бүрийн хэмнэлтийн хэмжээгээр нөөц үүсгэж байгаа нь төсвийг арвилан хэмнэлтгүй зарцуулах нөхцөлийг үүсгэж байна.
- 1.2. Эрсдэл: Төсвийн хөрөнгө арвилан хэмнэлтгүй зарцуулагдах.
- 1.3. Өгсөн зөвлөмж: Нөөцлөх бараа материалын тоо хэмжээг тодорхой тогтоох.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	248 182 524,79	260 097 857,01
34	УРЬДЧИЛГАА	6 774 118,00	13 222 726,40
3471	Урьдчилгаа тооцоо	6 774 118,00	13 222 726,40
34711	Бараа материал бэлтгэх урьдчилгаа	6 774 118,00	13 222 726,40
35	БАРАА МАТЕРИАЛ	241 408 406,79	246 875 130,61
351	Түүхий эд материал	80 024 058,39	69 972 264,21
35110	Тусгай зориулалттай материал	79 661 578,39	69 491 596,99
35130	Эм боох материал	362 480,00	480 667,22
354	Хангамжийн материал	108 664 348,40	121 042 866,40
35410	Бичиг хэргийн материал	35 330 954,00	30 894 153,00
35420	Аж ахуйн материал	52 159 614,40	64 278 464,40
35430	Сэлбэг хэрэгсэл	261 000,00	1 361 367,00
35440	Түлш, шатах тослох материал	83 833,00	74 433,00
35450	Барилгын засварын материал	220 000,00	220 000,00
35460	Хүнсний материал	278 353,00	246 505,00
35470	Бусад хангамжийн материал	20 330 594,00	23 967 944,00
35600	Мал амьтад	52 720 000,00	55 860 000,00
2	ЭРГЭЛТИЙН БҮС ХӨРӨНГИЙН ДҮН	2 618 725 902,33	2 726 222 090,59
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2 618 725 902,33	2 726 222 090,59
392	Биет хөрөнгө	1 990 182 152,33	2 096 868 340,59
39201	Барилга, байгууламж, орон сууц	1 536 353 447,30	1 556 146 252,30
39202	Хуримтлагдсан элэгдэл	-1 067 708,40	-33 552 584,32
39203	Авто-тээврийн хэрэгсэл	627 000 768,06	446 554 851,27
39204	Хуримтлагдсан элэгдэл	-472 393 099,98	-279 087 127,20
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	641 075 811,61	553 892 303,90
39206	Хуримтлагдсан элэгдэл	-436 215 353,34	-274 894 361,44
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	95 033 568,89	68 648 629,48
39208	Хуримтлагдсан элэгдэл	-64 486 152,86	-32 526 424,37
39211	Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	53 315 688,00	67 935 738,00
39214	Бусад үндсэн хөрөнгө	34 311 006,00	42 688 390,00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-22 745 822,95	-18 937 327,03
393	Биет бус хөрөнгө	628 543 750,00	629 353 750,00
39301	Програм хангамж	1 175 000,00	975 000,00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1 136 250,00	-126 250,00
39303	Бусад биет бус хөрөнгө	628 505 000,00	628 505 000,00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2 866 908 427,12	2 986 319 947,60
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2 866 908 427,12	2 986 319 947,60
51	Засгийн газрын хувь оролцоо	2 866 908 427,12	2 986 319 947,60
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1 858 536 152,27	1 858 536 152,27
51101	Өмч: - төрийн	1 858 536 152,27	1 858 536 152,27
512	Хуримтлагдсан үр дүн	-127 702 702,50	-7 575 009,75
51210	Өмнөх үеийн үр дүн	-127 702 702,50	-126 986 530,23
51220	Тайланг үеийн үр дүн	00,00	119 411 520,48
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1 136 074 977,35	1 135 358 805,08
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2 866 908 427,12	2 986 319 947,60



Цагдаагийн газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

			/төгрөг/
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (1)	2 886 682 779,00	3 212 637 213,80
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	362 678 043,00	393 484 476,80
120	Нийтлэг татварын бус орлого	362 678 043,00	393 484 476,80
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	95 280 460,00	270 608 968,00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	62 820 460,00	66 354 313,00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	32 460 000,00	204 254 655,00
120009	Бусад орлого	267 397 583,00	122 875 508,80
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2 524 004 736,00	2 819 152 737,00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2 432 602 200,00	2 696 387 000,00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2 432 602 200,00	2 696 387 000,00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	91 402 536,00	122 765 737,00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	70 275 471,00	2 340 000,00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	21 127 065,00	120 425 737,00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2 816 829 205,15	3 093 225 693,32
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2 816 829 205,15	3 093 225 693,32
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2 809 536 299,15	3 071 026 380,32
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2 179 127 524,00	2 434 617 164,00
210101	Үндсэн цалин	1 677 808 185,00	1 897 630 860,00
210102	Нэмэгдэл	483 142 481,00	507 700 873,00
210104	Урамшуулал	18 176 858,00	29 285 431,00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	46 729 677,00	55 301 496,00
210201	Тэтгэврийн даатгал	6 036 284,00	1 874 867,00
210202	Тэтгэмжийн даатгал	265 266,00	220 572,00
210203	ҮОМШӨ-ний даатгал	212 215,00	176 457,00
210204	Ажилгүйдлийн даатгал	53 053,00	44 114,00
210205	Эрүүл мэндийн даатгал	40 162 859,00	52 985 486,00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	42 870 543,00	47 392 160,00
210301	Гэрэл, цахилгаан	19 145 420,00	21 539 801,00
210302	Түлш, халаалт	18 975 838,00	21 248 221,00
210303	Цэвэр, бохир ус	4 749 285,00	4 604 138,00
2104	Хангамж, бараа материалын зардал	188 678 654,00	190 884 863,60
210401	Бичиг хэрэг	28 766 144,00	24 162 295,00
210402	Тээвэр, шатахуун	142 001 460,00	122 925 442,60
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	10 064 232,00	11 480 422,00
210404	Ном, хэвлэл	00,00	216 000,00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5 816 318,00	4 194 619,00
210408	Бараа материал акталсны зардал	2 030 000,00	27 906 085,00
2105	Нормативт зардал	42 046 468,00	44 086 192,78
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	324 010,00	729 847,78
210502	Хоол, хүнс	38 655 458,00	37 381 345,00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3 067 000,00	5 975 000,00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	77 867 894,00	51 814 669,00
210601	Багаж, техник, хэрэгсэл	136 000,00	345 699,00
210603	Хөдөлмөр хамтааллын хэрэглэл	79 600,00	125 600,00
210604	Урсгал засвар	77 652 294,00	51 343 370,00
2107	Томилолт, зочны зардал	18 340 000,00	18 340 000,00
210702	Дотоод албан томилолт	18 340 000,00	18 340 000,00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11 261 502,00	18 929 110,00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6 614 100,00	14 857 855,00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	360 000,00	360 000,00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1 386 173,00	997 252,00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	831 000,00	770 000,00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	561 000,00	675 000,00
210807	Газрын төлбөр	1 350 913,00	1 050 912,00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	158 316,00	218 091,00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	202 614 037,15	209 660 724,94
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	17 130 000,00	37 309 200,00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4 175 555,20	7 969 676,40
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	181 308 481,95	164 381 848,54
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7 292 906,00	22 199 313,00
2132	Бусад урсгал шилжүүлэг	5 794 302,00	13 084 356,00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5 794 302,00	13 084 356,00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1 498 604,00	9 114 957,00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00,00	9 114 957,00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	69 853 573,85	119 411 520,48
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	42 184 308,68	119 411 520,48



4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	2 586 825 196,00	2 885 507 050,00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	62 820 460,00	66 354 313,00
120	Нийтлэг татварын бус орлого	62 820 460,00	66 354 313,00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	62 820 460,00	66 354 313,00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	62 820 460,00	66 354 313,00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2 524 004 736,00	2 819 152 737,00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2 432 602 200,00	2 696 387 000,00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2 432 602 200,00	2 696 387 000,00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	91 402 536,00	122 765 737,00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	70 275 471,00	2 340 000,00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	21 127 065,00	120 425 737,00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	2 568 357 396,00	2 877 666 150,00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2 568 357 396,00	2 877 666 150,00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2 565 856 392,00	2 860 431 193,00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2 179 127 524,00	2 434 994 781,00
210101	Үндсэн цалин	1 386 388 746,00	1 500 779 550,00
210102	Нэмэгдэл	774 789 200,00	904 819 800,00
210104	Урамшуулал	17 949 578,00	29 395 431,00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	46 729 677,00	55 033 879,00
210201	Тэтгэврийн даатгал	11 067 384,00	240 300,00
210202	Тэтгэмжийн даатгал	00,00	28 300,00
210203	ҮОМШӨ-ний даатгал	00,00	22 600,00
210204	Ажилгүйдлийн даатгал	00,00	325 700,00
210205	Эрүүл мэндийн даатгал	35 662 293,00	54 416 979,00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	43 255 543,00	48 554 200,00
210301	Гэрэл, цахилгаан	19 145 420,00	21 539 801,00
210302	Түлш, халаалт	19 360 838,00	22 410 261,00
210303	Цэвэр, бохир ус	4 749 285,00	4 604 138,00
2104	Хангамж, бараа материалын зардал	141 341 803,00	137 115 234,00
210401	Бичиг хэрэг	26 461 698,00	18 644 038,00
210402	Тээвэр, шатахуун	102 175 516,00	102 526 450,00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	10 750 392,00	11 360 422,00
210404	Ном, хэвлэл	00,00	130 000,00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1 954 197,00	4 454 324,00
2105	Нормативт зардал	37 199 263,00	47 922 992,00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	686 490,00	729 390,00
210502	Хоол, хүнс	32 721 773,00	33 067 612,00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3 791 000,00	14 125 990,00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	81 172 524,00	59 602 369,00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2 840 459,00	1 281 600,00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	369 100,00	544 996,00
210604	Урсгал засвар	77 962 965,00	57 775 773,00
2107	Томилолт, зочны зардал	18 340 000,00	18 340 000,00
210702	Дотоод албан томилолт	18 340 000,00	18 340 000,00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12 692 058,00	13 927 870,00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8 850 145,00	10 826 706,00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	360 000,00	360 000,00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1 350 000,00	997 252,00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	781 000,00	693 000,00
210807	Газрын төлбөр	1 350 913,00	1 050 912,00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5 998 000,00	44 939 868,00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00,00	37 079 868,00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5 998 000,00	7 860 000,00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2 501 004,00	17 234 957,00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1 002 400,00	8 120 000,00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1 002 400,00	8 120 000,00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1 498 604,00	9 114 957,00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00,00	9 114 957,00



Цагдаагийн газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудит

3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	18 467 800,00	7 840 900,00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	18 467 800,00	7 840 900,00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	18 467 800,00	7 840 900,00
2200	Дотоод эх үүсвэрээр	18 467 800,00	7 840 900,00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	18 467 800,00	7 840 900,00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-18 467 800,00	-7 840 900,00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00,00	00,00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00,00	00,00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00,00	00,00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00,00	00,00

4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1 230 031 152,27	1 071 547 952,97	-26 258 991,20	2 275 320 114,03
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00,00	00,00	283 565,30	283 565,30
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1 230 031 152,27	1 071 547 952,97	-25 975 425,90	2 275 603 679,33
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00,00	00,00	00,00	00,00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00,00	00,00	00,00	00,00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00,00	00,00	00,00	00,00
C07	Тайлант үеийн үр дүн	628 505 000,00	00,00	42 184 308,68	670 689 308,68
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1 858 536 152,27	1 136 074 977,35	-127 702 702,50	2 866 908 427,12
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1 858 536 152,27	1 136 074 977,35	-127 702 702,50	2 866 908 427,12
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00,00	00,00	716 172,27	716 172,27
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1 858 536 152,27	1 136 074 977,35	-126 986 530,23	2 867 624 599,39
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00,00	-716 172,27	00,00	-716 172,27
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00,00	00,00	00,00	00,00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00,00	00,00	00,00	00,00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00,00	00,00	00,00	00,00
D08	Тайлант үеийн үр дүн	00,00	00,00	119 411 520,48	119 411 520,48
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1 858 536 152,27	1 135 358 805,08	-7 575 009,75	2 986 319 947,60



4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2 753 713 000,00	2 753 626 356,00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2 753 713 000,00	2 753 626 356,00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2 745 593 000,00	2 745 506 356,00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2 405 622 000,00	2 405 599 350,00
210101	Үндсэн цалин	1 500 802 200,00	1 500 779 550,00
210102	Нэмэгдэл	904 819 800,00	904 819 800,00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	51 373 200,00	51 373 200,00
210201	Тэтгэврийн даатгал	240 300,00	240 300,00
210202	Тэтгэмжийн даатгал	28 300,00	28 300,00
210203	ҮОМШӨ-ний даатгал	22 600,00	22 600,00
210204	Ажилгүйдлийн даатгал	5 700,00	5 700,00
210205	Эрүүл мэндийн даатгал	51 076 300,00	51 076 300,00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	48 554 300,00	48 554 200,00
210301	Гэрэл, цахилгаан	21 539 800,00	21 539 801,00
210302	Түлш, халаалт	22 410 300,00	22 410 261,00
210303	Цэвэр, бохир ус	4 604 200,00	4 604 138,00
2104	Хангамж, бараа материалын зардал	128 362 400,00	128 329 384,00
210401	Бичиг хэрэг	15 449 300,00	15 644 038,00
210402	Тээвэр, шатахуун	96 740 600,00	96 740 600,00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	11 588 200,00	11 360 422,00
210404	Ном, хэвлэл	130 000,00	130 000,00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4 454 300,00	4 454 324,00
2105	Нормативт зардал	34 280 000,00	34 279 102,00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	729 400,00	729 390,00
210502	Хоол, хүнс	33 050 600,00	33 067 612,00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	500 000,00	482 100,00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	46 320 000,00	46 319 956,00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2 000 000,00	1 882 600,00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	427 600,00	544 996,00
210604	Урсгал засвар	43 892 400,00	43 892 360,00
2107	Томилолт, зочны зардал	18 340 000,00	18 340 000,00
210702	Дотоод албан томилолт	18 340 000,00	18 340 000,00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10 741 100,00	10 711 164,00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр	8 000 000,00	7 970 000,00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	997 300,00	997 252,00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	693 000,00	693 000,00
210807	Газрын төлбөр	1 050 800,00	1 050 912,00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2000000,00	2000000,00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2 000 000,00	2 000 000,00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8120000,00	8120000,00
2132	Бусад урсгал шилжүүлэг	8 120 000,00	8 120 000,00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	8 120 000,00	8 120 000,00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2 753 713 000,00	2 753 626 356,00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2 696 387 000,00	2 696 356 952,00
131001	Улсын төсвөөс санхүүжих	2 696 387 000,00	2 696 356 952,00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих		
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	57 326 000,00	57 269 404,00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	57 326 000,00	57 269 404,00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	187	185
620001	Удирдах ажилтан	02	02
620002	Гүйцэтгэх ажилтан	180	178
620003	Үйлчлэх ажилтан	05	05